



БАГЦ ЦАГИЙН БОГИНО ХУГАЦААНЫ СУРГАЛТЫН ЭРХ ЗҮЙН БАРИМТ, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ҮР ДҮН

СУДАЛГААНЫ БАГ

Б. МӨНХЦЭЦЭГ (ХТХАА-ны мэргэжилтэн)

Ч. МИЧИДМАА (ХТХАА-ны мэргэжилтэн)

Л. ОЮУНБИЛЭГ (ХТХАА-ны мэргэжилтэн)

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох, журам”-ын 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.5, 9.2, 10.2 дахь заалтуудад багц цагийн богино хугацааны сургалт эрхлэх байгууллагын шаардлага, чадавхи, сургалтын чиглэл, зөвшөөрөл хүсэхэд бүрдүүлэх баримт бичиг болон сургалт удирдах багшид тавигдах шаардлагыг тусгасан байдаг.

Энэ журмын дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын 2018 оны А/20 дүгээр тушаалаар батлагдсан Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлөөр сургалт эрхлэх байгууллагын зөвшөөрөл, сургалтын чиглэлийг хэлэлцэн баталгаажуулах үйл ажиллагааг зохион байгуулдаг.

2019 онд тус зөвлөл нь 2 удаа хуралдаж 110 байгууллагын багц цагийн сургалт эрхлэх зөвшөөрлийн асуудлыг хэлэлцэн, зөвшөөрөл олгож, багц цагийн богино хугацааны 680 хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 145029 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамтрагдсан байна. Зайн сургалтыг 2019 онд сургалт эрхлэх 10 байгууллагатай хамтран 62 удаа зохион байгуулж, 3077 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. Цаашид эмч, эмнэлгийн мэргэжилтний богино хугацааны багц цагийн сургалтыг цаг үетэйгээ нийцсэн, цаг хугацаа хэмнэсэн, үр ашигтай зохион байгуулах, мэргэжил арга зүйгээр хангах хэрэгцээ өндөр байна.

Шинэ төрлийн коронавирусууд үүсгэгдсэн КОВИД-19 халдвар гарч, Улсын онцгой комиссын 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 1 дүгээр хурлын тэмдэглэлийн 5.1-д “Олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулахыг түр хугацаагаар хязгаарлахыг” үүрэг болгосны дагуу багц цагийн богино хугацааны сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах шаардлага тулгарч байна. Иймд эмнэлгийн мэргэжилтнүүдийн богино хугацааны багц цагийн сургалтын өнөөгийн нөхцөл байдлын дүн шинжилгээг хийж, цаашид цахим хэлбэрээр зохион байгуулах боломжийг судлах нь энэхүү судалгааны үндэслэл болно.

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТ

2.1 Зорилго

Багц цагийн богино хугацааны сургалтын талаарх эрх зүйн бичиг баримт, түүний хэрэгжилтэнд дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлж, цаашид хөгжүүлэх хэрэгцээг тодорхойлох

2.2 Зорилт:

1. Багц цагийн сургалтын талаарх эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийг судлах
2. Цахим болон онлайн сургалт явуулах эрх зүйн орчин бүрдсэн эсэх
3. Багц цагийн сургалтыг цахим хэлбэрээр явуулах эрхзүйн орчныг бүрдүүлэх

ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Баримтын судалгааны аргаар эмнэлэгийн мэргэжилтэний богино болон багц цагийн сургалт явуулахад мөрдөж буй хууль, журмын хэрэгжилт, цахим сургалтын талаарх заалтууд, сүүлийн жилүүдэд хийгдсэн багц цагийн сургалтын мэдээ, мэдээлэл зэргийг ашиглан явуулав.

Ашигласан хууль эрх зүйн баримтууд:

- Эрүүл мэндийн тухай хууль 2011
- Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам” 2018 он А/484
- Эрүүл мэндийн сайдын “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам” 2017 он А/337
- Эрүүл мэнд, спортын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2015 он 98
- Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын хамтарсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай” 2015 он 97/56
- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын “Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай” 2018 оны А/29, 2019 оны А/165

Богино хугацааны сургалтын хэрэгжилтийг 6 бүлэг болгон заалт бүрээр харьцуулан дүгнэж, цаашид сайжруулах, хэрэгжилтийг хангах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулсан.

2.1 Эрх зүйн баримтууд, тэдгээрийн хэрэгжилтийн байдал:

Судалгааны энэ бүлэгт эмнэлэгийн мэргэжилтний төгсөлтийн дараах тасралтгүй сургалт буюу багц цагийн богино хугацааны сургалтын талаарх эрх зүйн баримтуудыг Эрүүл мэндийн тухай хууль, салбарын сайд, ЭМХТ –ийн тушаал, журам зэргийг хамруулан харьцуулан судлав.

Хүснэгт 1.1 Эрх зүйн баримтуудад багц цагийн сургалтын талаар тусгагдсан байдал

Эрх зүйн баримтын нэр	Баримтын дугаар	Заалт	Хэрэгжилт
Эрүүл мэндийн		25.5 Резидент эмчээс бусад мэргэжлийн үйл ажиллагаа	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

тухай хууль 2011 он		эрхлэх зөвшөөрлийг жил тутам тасралтгүй сургалтад хамрагдаж, багц цагаа бүрдүүлэн ажилласан эмнэлгийн мэргэжилтэнд таван жилийн хугацаагаар сунгана.	олгох үйл ажиллагаа 2000 оноос эхэлсэн ба Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь эмчлэх, эм барих, сувилах, эх барих, сэргээн засах гэсэн төрөлтэй байна. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий Уламжлалт анагаах ухаан, нүүр ам, хүний их эмч, эм зүйч нар жилд 6 багц цаг, сувилагч, тусгай мэргэжилтэн жилд 3 багц цагийн сургалтад хамрагдахаар заасан байна. Эмнэлгийн мэргэжилтэн тасралтгүй сургалт буюу багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдсанаар зөвшөөрлийг сунгуулна.			
Эрх зүйн баримтын нэр			Заалт	Хэрэгжилт		
Эрүүл мэндийн тухай хууль 2011 он			25.5	+		
Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам” 2018	A/484	1.6 Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эрүүл мэндийн цахим мэдээллийн бодлогын хэрэгжилт хариуцсан нэгж нь хүний нөөцийн нэгдсэн программ хангамжийг үүсгэх, нэмэлт өөрчлөлт хийх, нууцлалыг хангах, бусад мэдээний сантай холбох, программ хангамжид нэвтрэх эрх олгох, хүчингүй болгох, мэдээний сангийн нөөцлөх болон программ хангамжийн аюулгүй ажиллагаа, нэгдсэн зохицуулалт, арга зүйгээр хангах, үйл ажиллагааг,	Эмнэлгийн мэргэжилтний нэгдсэн бүртгэлийн сан байхгүй.			

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

		<p>эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, мэргэжлийн хөгжил, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан нэгж нь бүртгэлийн сангийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, өөрийн хариуцсан асуудлын хүрээнд мэдээллийг шинэчлэх, эрүүл мэндийн байгууллагуудад арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээллийг нэгтгэх, тайлагнах үйл ажиллагааг тус тус хариуцана.</p>				
Эрх зүйн баримтын нэр		Заалт	Хэрэгжилт			
			<table border="1"> <tr> <td style="text-align: center;">Бүрэн</td> <td style="text-align: center;">Дутуу</td> <td style="text-align: center;">Хэрэгжихгүй</td> </tr> </table>	Бүрэн	Дутуу	Хэрэгжихгүй
Бүрэн	Дутуу	Хэрэгжихгүй				
Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн санг хөтлөх, мэдээллийг шинэчлэх, ашиглах журам” 2018 он А/484		1.6	+			
<p>Эрүүл мэндийн сайдын “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам” 2017 он</p>	А/337	<p>2.4.Төгсөлтийн дараахь сургалт нь зайн сургалтын хэлбэрээр явагдаж болно.</p>	<p>Эрүүл мэндийн хөгжлийн төвд зайн сургалтын төв ажиллаж байгаа боловч Эмнэлгийн мэргэжилтний багц цагийн богино хугацааны сургалтад ашиглалт хангалтгүй байна. 2016 он хүртэл ЭМХТ Сургалт эрхлэх байгууллагын эмч, багш нараар аймаг, нийслэлээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тодорхой сэдвийн хүрээнд товч, тодорхой сургалтын материал бэлтгүүлэн зайн сургалт зохион байгуулж байсан. Энэ нь нэг талаар богино хугацаанд дагнасан 1 сэдвээр хангалттай мэдээлэл өгч, мөн харилцан эмч,</p>			

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

		<p>эмнэлгийн мэргэжилтнүүд тулгамдсан асуудлаар мэдээллээ солилцож мэргэжлийн эмч, багш нараас зөвлөгөө авч болохоор давуу талтай боловч багц цаг тооцох, үнэлэхэд хүндрэл гарч байсан.</p> <p>Одоогоор УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, АШУҮИС зэрэг байгууллагууд зайн сургалт зохион байгуулдаг. Эмнэлгүүдийн хувьд зайн сургалтыг ихэвчлэн зөвлөгөө, мэдээллийн журмаар ашигладаг. Багц цагийн богино хугацааны сургалтад зайн сургалтыг идэвхтэй ашиглаж байгаа байгууллага одоогоор байхгүй байна. Мөн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд зайн сургалтаар суралцах сонирхол бага, хүсэлт гаргадаггүй. Багц цаг авахын тулд хэд хэдэн удаагийн болон цуврал зайн сургалтад хамрагдсанаар олгогддог.</p>	
	<p>2.6.2. багц цагийн богино хугацааны сургалтын хувьд нэг сар хүртэл.</p>		<p>Багц цагийн сургалт нь журамд 1 сар хүртэл гэж заасан боловч зохион байгуулагдаж буй сургалтын 90 орчим хувь нь 1-3 хоног байна. Мөн сургалт зохион байгуулагч байгууллагууд багц цаг илүү зөвшөөрөл авахын тулд зохиолмолоор хугацааг урт төлөвлөх тохиолдол байдаг. Энэ нь хяналтын үйл ажиллагаа дутмагаас шалтгаалдаг.</p>
		<p>3.3. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Мэргэжлийн</p>	

		<p>салбар зөвлөл нь төгсөлтийн дараахь сургалтын чиглэлээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p>						
		<table border="1"> <tr> <td data-bbox="595 302 1046 459"> <p>3.3.1. Тасралтгүй сургалт эрхлэх байгууллагаас боловсруулсан сургалтын хөтөлбөр, хугацааг батлах;</p> </td> <td data-bbox="1046 302 1513 878"> <p>Тасралтгүй сургалтад мэргэжил дээшлүүлэх болон багц цагийн сургалт хамаарч байгаа ба мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг Мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулдаг. Багц цагийн сургалтын хувьд өдөр тутмын үйл ажиллагаа тул мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэх боломжгүй.</p> </td> </tr> </table>	<p>3.3.1. Тасралтгүй сургалт эрхлэх байгууллагаас боловсруулсан сургалтын хөтөлбөр, хугацааг батлах;</p>	<p>Тасралтгүй сургалтад мэргэжил дээшлүүлэх болон багц цагийн сургалт хамаарч байгаа ба мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг Мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулдаг. Багц цагийн сургалтын хувьд өдөр тутмын үйл ажиллагаа тул мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэх боломжгүй.</p>				
<p>3.3.1. Тасралтгүй сургалт эрхлэх байгууллагаас боловсруулсан сургалтын хөтөлбөр, хугацааг батлах;</p>	<p>Тасралтгүй сургалтад мэргэжил дээшлүүлэх болон багц цагийн сургалт хамаарч байгаа ба мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг Мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулдаг. Багц цагийн сургалтын хувьд өдөр тутмын үйл ажиллагаа тул мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэх боломжгүй.</p>							
		<p>3.4. Ажлын алба нь төгсөлтийн дараахь сургалтын чиглэлээр дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:</p>						
		<table border="1"> <tr> <td data-bbox="595 978 1046 1350"> <p>3.4.5. Жил бүрийн тасралтгүй сургалтын чиглэлийг журмын 1.3-т заасан зөвлөмжийн дагуу боловсруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын шийдвэрээр батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах;</p> </td> <td data-bbox="1046 978 1513 1476"> <p>Ажлын алба нь жил бүрийн эхэнд сургалт эрхлэгч байгууллагаас ирүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөөг төвийн дэргэдэх Тасралтгүй сургалтын эрх олгох зөвлөлөөр хэлэлцүүлэн зөвшөөрөл олгодог боловч Багц цагийн сургалтаар тухайн жилийн хэрэгцээ болон тэргүүлэх чиглэлийг тодорхойлдоггүй.</p> </td> </tr> <tr> <td data-bbox="595 1485 1046 1942"> <p>3.4.6. мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлагын төслийг боловсруулах, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс баталсан дэлгэрэнгүй шаардлагыг сургалт эрхлэх байгууллагад танилцуулж, мөрдүүлэх;</p> </td> <td data-bbox="1046 1485 1513 2060"> <p>Мэргэшүүлэх сургалтын хувьд 2019 онд хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлага боловсрогдон гарч, Сургалт эрхлэх байгууллагуудад хүргүүлсэн. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс багц цагийн богино хугацааны сургалтын хөтөлбөрийн жишиг загвар гарган сургалт эрхлэх байгууллагууд мөрдөн ажилладаг.</p> </td> </tr> <tr> <td data-bbox="595 1951 1046 2060"> <p>3.4.7. Сургалтын хөтөлбөр боловсруулах заавар гарган, эрүүл мэндийн</p> </td> <td data-bbox="1046 1951 1513 2060"></td> </tr> </table>	<p>3.4.5. Жил бүрийн тасралтгүй сургалтын чиглэлийг журмын 1.3-т заасан зөвлөмжийн дагуу боловсруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын шийдвэрээр батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах;</p>	<p>Ажлын алба нь жил бүрийн эхэнд сургалт эрхлэгч байгууллагаас ирүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөөг төвийн дэргэдэх Тасралтгүй сургалтын эрх олгох зөвлөлөөр хэлэлцүүлэн зөвшөөрөл олгодог боловч Багц цагийн сургалтаар тухайн жилийн хэрэгцээ болон тэргүүлэх чиглэлийг тодорхойлдоггүй.</p>	<p>3.4.6. мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлагын төслийг боловсруулах, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс баталсан дэлгэрэнгүй шаардлагыг сургалт эрхлэх байгууллагад танилцуулж, мөрдүүлэх;</p>	<p>Мэргэшүүлэх сургалтын хувьд 2019 онд хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлага боловсрогдон гарч, Сургалт эрхлэх байгууллагуудад хүргүүлсэн. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс багц цагийн богино хугацааны сургалтын хөтөлбөрийн жишиг загвар гарган сургалт эрхлэх байгууллагууд мөрдөн ажилладаг.</p>	<p>3.4.7. Сургалтын хөтөлбөр боловсруулах заавар гарган, эрүүл мэндийн</p>	
<p>3.4.5. Жил бүрийн тасралтгүй сургалтын чиглэлийг журмын 1.3-т заасан зөвлөмжийн дагуу боловсруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын шийдвэрээр батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах;</p>	<p>Ажлын алба нь жил бүрийн эхэнд сургалт эрхлэгч байгууллагаас ирүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөөг төвийн дэргэдэх Тасралтгүй сургалтын эрх олгох зөвлөлөөр хэлэлцүүлэн зөвшөөрөл олгодог боловч Багц цагийн сургалтаар тухайн жилийн хэрэгцээ болон тэргүүлэх чиглэлийг тодорхойлдоггүй.</p>							
<p>3.4.6. мэргэшүүлэх болон тасралтгүй сургалтын хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлагын төслийг боловсруулах, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөс баталсан дэлгэрэнгүй шаардлагыг сургалт эрхлэх байгууллагад танилцуулж, мөрдүүлэх;</p>	<p>Мэргэшүүлэх сургалтын хувьд 2019 онд хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлага боловсрогдон гарч, Сургалт эрхлэх байгууллагуудад хүргүүлсэн. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс багц цагийн богино хугацааны сургалтын хөтөлбөрийн жишиг загвар гарган сургалт эрхлэх байгууллагууд мөрдөн ажилладаг.</p>							
<p>3.4.7. Сургалтын хөтөлбөр боловсруулах заавар гарган, эрүүл мэндийн</p>								

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

	<p>байгууллага, анагаах ухааны боловсролын байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоо, сургалт эрхлэх байгууллага (сургалт эрхлэх байгууллагын сүлжээ)-д арга зүйн дэмжлэг үзүүлэх;</p>	<p>Сургалтын хөтөлбөрийг тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн хянаж зөвлөгөө өгч ажилладаг. Шаардлага хангасан сургалтын хөтөлбөрт сургалт явуулах зөвшөөрөл олгодог боловч хөтөлбөрт тавигдах шаардлага боловсрогдож, баталгаажуулагдахгүй.</p>
	<p>3.4.10. Тасралтгүй сургалт эрхлэх байгууллагаас боловсруулсан сургалтын хөтөлбөр, хугацааг холбогдох мэргэжлийн салбар зөвлөлөөс баталсаны дараа тасралтгүй сургалтын хөтөлбөрт тавигдах дэлгэрэнгүй шаардлагын дагуу эсэхийг хянаж, шаардлага хангасан тохиолдолд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлаар зөвшөөрүүлэх, тасралтгүй сургалтын хөтөлбөрийг хоёроос гурван жил тутамд үнэлэх ажлыг зохион байгуулж, Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн хурлаар үнэлгээний дүнг хэлэлцүүлэх;</p>	<p>Энэ заалтад заасанаар Эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалт буюу мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, хугацааг мэргэжлийн салбар зөвлөл хянаж баталгаажуулдаг. Багц цагийн сургалтын хувьд сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлэх боломжгүй байна. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ хийгдэж байгаагүй ба үнэлгээний мэргэжлийн баг хэрэгтэй.</p>
	<p>3.4.11. энэхүү журмын 3.4.5-д заасан чиглэлийн дагуу тасралтгүй сургалтын сургалт эрхлэх байгууллагад Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлаар баталгаажуулсан гэрчилгээг нэг жилийн хугацаагаар олгох;</p>	<p>Сургалт эрхлэгч байгууллагатай тухайн жил сургалт зохион байгуулах гэрээ байгуулан ажилладаг. Гэрчилгээ олгогддоггүй.</p>

		<p>3.4.17. төгсөлтийн дараахь зайн сургалтын журмыг боловсруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын шийдвэрээр батлуулах, зайн сургалтын төвийн үүрэг гүйцэтгэн, сургалт эрхлэх байгууллагын дэргэдэх зайн сургалтын салбар төвийг байгуулахад дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааны уялдааг зохицуулах;</p>	<p>Төгсөлтийн дараах зайн сургалтын журамгүй.</p> <p>Тус төвийн дэргэд зайн сургалт зохион байгуулах тоног төхөөрөмжөөр хангагдсан боловч зайн сургалт зохион байгуулагдаж чадахгүй байна.</p>
		<p>3.4.28. элсэгч, суралцагч, төгсөгчтэй холбоотой цахим мэдээний санг тогтмол ажиллуулах, боловсронгуй болгох, хяналт тавих;</p>	<p>Тасралтгүй сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний бүртгэл, сургалт эрхлэх байгууллагын талаархи EXCEL файл бүхий мэдээний сан хөтлөгддөг боловч мэргэжилтний тогтворгүй байдлаас болж 2018, 2019 он хангалтгүй хөтлөгдсөн байна.</p>
		<p>Тав. Төгсөлтийн дараахь тасралтгүй сургалтын зохион байгуулалт</p>	
		<p>5.1. Тасралтгүй сургалт нь Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс тухайн чиглэлээр зөвшөөрөл авсан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллага, анагаах ухааны боловсролын байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоонд түшиглэн явагдана.</p>	<p>Тасралтгүй сургалтыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэдэх “Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн зөвшөөрөл авсан Эрүүл мэндийн байгууллага болон анагаах ухааны боловсролын байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоод эрхэлдэг. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэдэх Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлийн хурлын шийдвэрээр 2015 онд 113 байгууллагын 603 сургалтын хөтөлбөрөөр давхардсан</p>

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

			<p>тоогоор нийт 114225 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 2016 онд 30 байгууллагын 593 сургалтын хөтөлбөрөөр давхардсан тоогоор нийт 65874 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, 2017 онд 124 байгууллагын 1156 сургалтын хөтөлбөрөөр давхардсан тоогоор нийт 166560 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.</p>
		<p>5.3.3. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэдэх төгсөлтийн дараахь зайн сургалтын төвийн салбар төвийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах;</p>	<p>Эрүүл мэндийн хөгжлийн төвд зайн сургалтын төв ажиллаж байгаа боловч Эмнэлгийн мэргэжилтний багц цагийн богино хугацааны сургалтад ашиглалт хангалтгүй байна. 2016 он хүртэл ЭМХТ Сургалт эрхлэх байгууллагын эмч, багш нараар аймаг, нийслэлээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тодорхой сэдвийн хүрээнд товч, тодорхой сургалтын материал бэлтгүүлэн зайн сургалт зохион байгуулж байсан. Энэ нь нэг талаар богино хугацаанд дагнасан 1 сэдвээр хангалттай мэдээлэл өгч, мөн харилцан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд тулгамдсан асуудлаар мэдээллээ солилцож мэргэжлийн эмч, багш нараас зөвлөгөө авч болохоор давуу талтай боловч багц цаг тооцох, үнэлэхэд хүндрэл гарч байсан.</p> <p>Мөн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд зайн сургалтаар суралцах сонирхол бага, хүсэлт гаргадаггүй. Багц цаг авахын</p>

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

			тулд хэд хэдэн удаагийн болон цуврал зайн сургалтад хамрагдсанаар олгогддог.
		<p>5.3.4. энэхүү журмын 5.3.3-т заасан төгсөлтийн дараахь зайн сургалтын салбар төв байхгүй тохиолдолд төгсөлтийн дараахь сургалт эрхлэх бусад байгууллагын дэргэдэх салбар төвтэй гэрээ байгуулж, зайн сургалтыг зохион байгуулах;</p>	<p>Одоогоор УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, АШУУИС зэрэг байгууллагууд зайн сургалт зохион байгуулдаг. Эмнэлгүүдийн хувьд зайн сургалтыг ихэвчлэн зөвлөгөө, мэдээллийн журмаар ашигладаг. Багц цагийн богино хугацааны сургалтад зайн сургалтыг идэвхтэй ашиглаж хамтран ажиллаж байгаа байгууллага одоогоор байхгүй байна.</p>
		<p>5.3.6. багц цагийн богино хугацааны сургалтын хувьд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын баталсан сургалтын чиглэл, суралцагчдын тооны дагуу суралцагчид олгох гэрчилгээг урьдчилан хэвлэж, тухайн сургалт дуусгавар болохоос ажлын гурваас доошгүй хоногийн өмнө ажлын албанд хүргүүлэх;</p>	<p>Зөвшөөрөл авсан сургалтын хөтөлбөрийн дагуу суралцагчдад олгох гэрчилгээг урьдчилан хэвлүүлж баталгаажуулдаг боловч ихэнх багц цагийн сургалт 1-2 хоногт хийгддэг тул ихэвчлэн сургалт эхлэхээс өмнө буюу сургалт явагдах өдөр баталгаажуулагддаг. Явцын хяналт хангалтгүйгээс тухайн сургалтад баталгаажуулсан гэрчилгээний тоогоор эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан эсэхэд хяналт тавих боломжгүй. Мөн сургалт эрхлэх байгууллагууд сургалт дууссан өдрөө бүртгэлээ ирүүлдэггүй, сургалтын цахим систем байхгүйгээс гэрчилгээ үнэгүй тараах болон худалдах асуудал үүсдэг.</p>
		<p>Долоо. Төгсөлтийн дараахь сургалтын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага</p>	
		<p>7.1.3. Төгсөлтийн дараах сургалт нь өмнөх түвшний</p>	<p>Багц цагийн богино хугацааны сургалтын</p>

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

	<p>сургалтын агуулгатай давхардаагүй, суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлагыг тасралтгүй ахиулахад чиглэсэн байх;</p>	<p>хөтөлбөрийн агуулга нь сургалт эрхлэх байгууллагын үйл ажиллагаа, мэргэжлийн үндсэн чиг үүрэг, эмнэлгийн мэргэжилтний эрхэлж буй мэргэжлийн үйл ажиллагаатай нийцсэн байх ба тодорхой нэг чиглэлээр дагнасан сэдвийн хүрээнд нотолгоонд тулгуурласан анагаах ухаан, эмнэл зүйн удирдамжид нийцүүлэн боловсруулсан байх ёстой. Гэхдээ тухайн хөтөлбөрийг дээрх шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах байнгын үйл ажиллагаатай мэргэжилтэн мэргэжлийн багийн үйл ажиллагаа дутмаг байна.</p> <p>Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт нэртэй боловч ихэнх багц цагийн богино хугацааны сургалтын хөтөлбөр бакалаврийн түвшний мэдлэгийг түгээж байна. Мөн Монгол улсад явагдаж байгаа дийлэнх сургалт ур чадвар олгох, асуудалд суурилсан хэлбэрээр бус дидактив арга барилаар зохион байгуулагдаж байна.</p>
	<p>Найм. Төгсөлтийн дараахь сургалт эрхлэх байгууллагад тавигдах шаардлага, бүрдүүлэх материал</p>	
	<p>8.2. Эмнэл зүйн бус мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалт, багц цагийн богино хугацааны сургалт эрхлэх байгууллага нь дараахь шаардлагыг хангасан байна</p>	<p>Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх</p>

		<p>9.3. Багц цагийн богино хугацааны болон эмнэл зүйн бус мэргэжил дээшлүүлэх сургалт эрхлэх байгууллага нь зөвшөөрөл хүсэхэд дараахь баримт бичгийг бүрдүүлэн ажлын албанд ирүүлнэ.</p>	<p>байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”-ын 9.1 дугаар зүйлд заасны дагуу баримт бичиг бүрдүүлэн багц цагийн сургалт эрхлэх хүсэлтийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ажлын албанд ирүүлж тухайн жилд багц цагийн сургалт эрхлэх зөвшөөрлийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэдэх “Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлэн олгодог. Зөвлөлд ЭМХТ болон АШУҮИС-ийн төлөөлөл багтсан байна.</p>
		<p>10.2. Багц цагийн богино хугацааны болон эмнэл зүйн бус мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалт удирдах багш дараахь шаардлагыг хангасан байна:</p>	<p>Төрийн байгууллага буюу төв болон төрөлжсөн мэргэжлийн төв, Анагаах ухааны боловсрол олгох их дээд сургуулиудын хувьд мэргэжлийн боловсон хүчин хангалттай байдаг. Харин мэргэжлийн нийгэмлэг холбоодын багц цагийн сургалтын багшлах боловсон хүчинд мөн төв эмнэлэг, төрөлжсөн мэргэжлийн төв, их дээд сургуулийн багш нар багтана.</p>
		<p>14.5. Багц цагийн богино хугацааны сургалтыг жилийн туршид зохион байгуулах бөгөөд энэхүү журмын 3.4.5-д заасны дагуу жил бүр явагдана.</p>	<p>Багц цагийн богино хугацааны сургалт эь жил бүрийн 1 дүгээр сараас эхлэн сургалт зохион байгуулах эрх авсан байгууллагууд жилийн туршид зохион байгуулдаг. Тухайн сургалт эрхлэх байгууллага сургалтын эрхийг жил бүр авах ёстой. Өнөөгийн үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан 2020 оны багц</p>

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

			цагийн сургалтууд явагдахгүй байна.			
Эрх зүйн баримтын нэр			Заалт	Хэрэгжилт		
				Бүрэн	Дутуу	Хэрэгжихгүй
Эрүүл мэндийн сайдын “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам” 2017 он А/337			2.4			+
			2.6.2	+		
			3.3.1		+	
			3.4.5		+	
			3.4.6		+	
			3.4.7		+	
			3.4.10			+
			3.4.11	+		
			3.4.17			+
			3.4.28			+
			5.1	+		
			5.3.3			+
			5.3.4			+
			5.3.6	+		
			7.1.3		+	
			8.2	+		
			9.3	+		
10.2	+					
14.5	+					
Эрүүл мэнд, спортын сайдын “Журам шинэчлэн батлах тухай”	98	7.1 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын агуулгын багтаамжийг багц цагаар тодорхойлно. Уг сургалтын 1 багц цаг нь лекцийн 12, дадлагын 24 цагтай тус тус дүйцнэ.	Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг сунгуулахын тулд эмч, эмнэлгийн мэргэжилтэн бүр эдгээр заалтуудыг мөрдөн ажиллаж хэвшсэн. Гэвч эмч, эмнэлгийн мэргэжилтний дийлэнх хувь нь мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх бус			

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

	<p>7.2 Зөвшөөрөл бүхий хүний их эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эм зүйч жил тутам 6 багц цаг, хүний бага эмч, эх баригч, сувилагч, эм найруулагч жил тутам 3 багц цагийн багтаамж бүхий сургалтанд хамрагдана.</p>	<p>аль болох тааралдсан сургалтандаа хамрагдан багц цагаа л цуглуулах сонирхолтой байдаг. Сургалт эрхлэх байгууллага, мэргэжлийн нийгэмлэг холбоод хангалттай тоотой нь сайшаалтай боловч мэргэжлийн нийгэмлэг холбоод болон мэргэжлийн салбар зөвлөлүүд тухайн мэргэжлийн чиглэлийн эмч, мэргэжилтнүүдээ үе шаттай хөгжүүлэх бодлого баримталдаггүй, тухайн мэргэжлийн мэргэжилтнүүдийн нэгдсэн бүртгэл байдаггүй.</p>
	<p>7.3 Аймгийн төвөөс 100 ба түүнээс дээш км-т алслагдсан нутагт ажиллаж байгаа бол их эмч, эм зүйч жил тутам 4 багц цаг, сувилагч, эм найруулагч, бага эмч, эх баригч жил тутам 2 багц цагийг бүрдүүлнэ.</p>	<p>Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь үндсэн болон, төрөлжсөн мэргэжлээр бус зөвхөн эмчлэх гэсэн нэг төрөлтэй тул эмч нар чиглэл харгалзахгүй сургалтад хамрагдах хандлагатай байдаг.</p>
	<p>7.5 Эмнэлгийн мэргэжилтний жил тутам биелүүлэх багц цагийн 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж байгаа мэргэжлийн чиглэлээр, бусад нь ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр байна.</p>	<p>Мөн журамд лекцийн цаг нь илүү багц цаг олгогдохоор заагдсан тул сургалт зохион байгуулагч байгууллагууд энэ хэлбэрийн сургалтыг илүүд үздэг. Уг нь эмнэл зүйн дадлага сургалт нь хүнд мэдлэг, ур чадвар олгохдоо хавьгүй илүү болох нь нотлогдсон тул багц цагийн хувьд дидактив сургалтаас илүү байх ёстой. Зарим сургалт эрхлэх байгууллагын хувьд багц цагийн сургалт бизнес болж хувирснаас аль болох нэг дор олон хүн хамруулж богино хугацаанд сургалт хийхийг зорих болсон.</p>

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

			Энэ нь чанаргүй болох үндэс болж байна. Мөн мөрдөгдөж буй журмаар зөвхөн сургалтаар багц цаг бүрдүүлэх бус судалгааны ажил удирдах, судалгааны багт орж ажиллах, мэргэжлийн ном орчуулах, хамтран ажиллах, мэргэжлийн сургалтад хичээл заах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хийх зэргээр багц цаг тооцуулж болохоор заасан.			
Эрх зүйн баримтын нэр			Заалт	Хэрэгжилт		
				Бүрэн	Дутуу	Хэрэгжихгүй
Эрүүл мэнд, спортын сайдын “Журам шинэчлэн батлах тухай” 2015 он 98			7.1, 7.2 7.3, 7.5	+		
Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын хамтарсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай”	97/56	Багц цагийн сургалтын төлбөрийн жишгийг баталсан.	Сургалт эрхлэх байгууллагууд энэхүү заалтыг мөрддөггүй. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн зүгээс хяналт тавьдаггүй.			
		Хамрагдсан мэргэжилтний тоо	1 багц цагийн төлбөр			
		60 хүртэл	12000			
		61-150	8000			
		151-ээс дээш	6000			
Эрх зүйн баримтын нэр			Заалт	Хэрэгжилт		
				Бүрэн	Дутуу	Хэрэгжихгүй
Эрүүл мэнд, спортын сайд, сангийн сайдын хамтарсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээг тогтоох тухай”			97/56			+

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

2015 он					
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын “Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай”	2018 он A/29 2019 он A/165				Уг тушаалаар Тасралтгүй сургалт эрхлэх эрх хүссэн байгууллагад эрх олгох үйл ажиллагааг зохицуулдаг. 6 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус зөвлөл ажиллах ба тушаалд зөвлөлийн ажиллах эрх үүрэг, зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх үүргийг тусгасан. Комисс нь оны эхэнд хүсэлт гаргасан байгууллагын материалыг хэлэлцэн жилийн турш сургалт явуулах эрхийг олгодог.
Эрх зүйн баримтын нэр		Заалт	Хэрэгжилт		
			Бүрэн	Дутуу	Хэрэгжихгүй
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын “Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай”		2018 /A/29/ 2019 /A/165/	+		

2.2. Төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах, ажлын албаны хүний нөөц

Эрх зүйн баримт бичигт: Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах үйл ажиллагааг ЭМЯ, ЭМХТ удирдан зохион байгуулдаг. Эрүүл мэндийн яам нь хууль эрх зүйн баримт бичиг, бодлого боловсруулах, төгсөлтийн дараах сургалтын журмыг хэрэгжүүлэн ЭМХТ-д техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлж ажилладаг. Эрүүл мэндийн яаманд Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөл ажилладаг ба энэ нь төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар ханган, шийдвэр гаргах үүрэгтэй ажилладаг. Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн ажлын алба нь ЭМХТ-ийн Хүний нөөцийн бодлого зохицуулалтын алба юм. Тус алба нь 1 дарга, 8 мэргэжилтэнтэй. Төгсөлтийн дараах сургалт хариуцсан 3, тасралтгүй сургалт хариуцсан 1 мэргэжилтэн ажиллаж байна. Ийм цомхон бүрэлдэхүүнтэй алба нь улсын хэмжээнд Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг удирдан зохион байгуулахад чадавхи дутдаг.

Журмын хэрэгжилт ба сайжруулах чиглэл

1. Журмын дагуу **хэрэгжиж байгаа 10 заалт** байгаа хэдий ч сайжруулах зарим заалтууд байна. Жишээлбэл:
 - Журамд эмнэлгийн мэргэжилтний жил тутамд биелүүлэх багц цагийн 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж байгаа мэргэжлийн чиглэлээр, бусад нь ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр байна гэж заасан. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь үндсэн болон, төрөлжсөн мэргэшлээр бус зөвхөн эмчлэх гэсэн нэг ерөнхий төрөлтэй, үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн дипломыг сунгуулах заалтгүй тул эмч нар чиглэл харгалзахгүй сургалтад хамрагдах хандлагатай байна. Мөн зөвшөөрөл сунгуулахад бүрдүүлэх баримт бичигт үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн үнэмлэх шаарддаггүй нь тухайн хүний хамрагдсан сургалтын хэрэгцээг үнэн бодитой үнэлэхэд дутагдалтай байна.
 - Багц цагийн сургалтын кредит тооцох аргачлалын хувьд 1 багц цаг нь лекцийн 12, дадлагын 24 цагтай тус тус дүйцнэ гэж заасан нь лекцийн цаг нь илүү багц цаг олгогдохоор заагдсан тул сургалт зохион байгуулагч байгууллагууд энэ хэлбэрийн сургалтыг илүүд үздэг. Уг нь эмнэл зүйн дадлага сургалт нь хүнд мэдлэг, ур чадвар олгохдоо хавьгүй илүү болох нь нотлогдсон тул багц цагийн хувьд дидактив сургалтаас илүү байх ёстой. Зарим сургалт эрхлэх байгууллагын хувьд багц цагийн сургалт бизнес болж хувирснаас аль болох нэг дор олон хүн хамруулж богино хугацаанд сургалт хийхийг зорих болсон. Энэ нь чанаргүй сургалт зохион байгуулах болох үндэс болж байна.
 - Журамд заасан шалгуур хангасан байгууллагуудад багц цагийн сургалтын эрхийг олгохдоо зохион байгуулах сургалтын чиглэл нь зөвхөн тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэлийн дагуу байвал зохино. Мөн сургалтад хамрагдах эмнэлгийн мэргэжилтэн нь мөн тухайн мэргэшлийн

дагуу байхад шаардлага тавих нь зүйтэй. Мөн сургалт зохион байгуулж буй байгууллагын жил бүрийн сургалтын агуулга хир шинэчлэгдэж байгаа, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх түвшний байна уу, үгүй юу гэдэгт өмнөх оны сургалтын хөтөлбөртэй харьцуулан үнэлж байх шаардлагатай. Гэвч тасралтгүй сургалт хариуцсан мэргэжилтэн нь тийм чадвартай байгаа эсэхэд эргэлзээтэй. Жил бүр дарга солигдох тутамд мэргэжилтэн солигдоно, эсвэл ажлын туршлага багатай мэргэжилтэн ажиллах гэх мэт.

- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэдэх Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, эрх үүргийг тодорхой болгох шаардлагатай. Мөн энэ зөвлөлийн чадавхийн асуудал чухал үүрэгтэй. Одоо ажиллаж байгаа зөвлөлийн бүрэлдэхүүн нь олон талыг төлөөлөх төлөөлөл болж чадахгүй байна

2. **Дутуу хэрэгжиж байгаа** заалтуудыг авч үзвэл ЭМХТ-ийн үйл ажиллагаатай холбоотой хэрэгжүүлж болох заалтууд хамаарч байна. Энэ хэсэгт хамгийн гол нь сургалтын хөтөлбөрийн агуулгад онцгойлон анхаарах хэрэгтэй байна. Олон хөтөлбөр цуглуулж олон сургалт зохион байгуулахдаа гол биш шинээр болон шинэчлэн батлагдсан эмнэл зүйн удирдамжийг хэрэгжүүлэх явцтай уялдуулах шаардлагатай. Мөн хяналт, үнэлгээ, судалгааны дүнд үндэслэсэн сургалтын хэрэгцээг жил бүр гаргадаг байвал зохино. Сургалтаар олж авсан мэдлэг, ур чадвар нь өдөр тутмын ажилд ашиглагдах бололцоотой байх нь чухал.

Сургалт эрхлэх байгууллагын үүрэг, хариуцлагыг сайжруулах шаардлагатай. Сургалт эрхлэх байгууллага, мэргэжлийн нийгэмлэг холбоод хангалттай тоотой нь сайшаалтай боловч мэргэжлийн нийгэмлэг холбоод болон мэргэжлийн салбар зөвлөлүүд тухайн мэргэжлийн чиглэлийн эмч, мэргэжилтнүүдээ үе шаттай хөгжүүлэх бодлого баримталдаггүй, тухайн мэргэжлийн мэргэжилтнүүдийн нэгдсэн бүртгэл байдаггүй.

3. **Хэрэгжихгүй байгаа** заалтуудын хувьд ЭМЯ болон ЭМХТ-ийн аль алины оролцоо чухал үүрэгтэй харагдаж байна.

- Эмнэлгийн мэргэжилтний хүний нөөцийн мэдээний сан: Хүний нөөцийн мэдээний сан байхгүйн улмаас тухайн эмнэлгийн мэргэжилтний үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмшсэн нэгдсэн мэдээлэл байхгүй, тухайн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаанд хамрагдсан сургалтын нэгдсэн мэдээлэл байхгүй. Мөн хүний нөөцийн мэдээний сантай сургалтын цахим систем хамт нэгдэж ажиллах шаардлагатай. ЭМХТ-д төгсөлтийн дараах сургалтын болон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ихэнх үйл ажиллагаа механик хэлбэрээр явагддаг. Энэ нь цаг хугацаа их шаарддаг тул тухайн мэргэжилтэн өөрийн хариуцсан ажлын хүрээнд хяналт үнэлгээний үйл ажиллагаа орхигддог.
- Зайн сургалтыг хөгжүүлэх: Зайн сургалттай холбоотой заалт байгаа хэдий ч 2017 оноос одоог хүртэл хэрэгжүүлээгүй байна. ЭМХТ нь журмын хэрэгжилтийг ханган ажиллаагүй, ЭМЯ хэрэгжилтэд хяналт тавьдаггүй нь

харагдаж байна. Журмаар зайн сургалтыг хэрхэн зохион байгуулж, хэрэгжүүлэхийг тодорхой заасан байна. Сургалт эрхлэх зарим нэг байгууллага зайн сургалтыг зохион байгуулдаг. Гэхдээ зайн сургалтын нэгдсэн журам байхгүйгээс зайн сургалтын агуулга, хугацаа, тооцох багц цагийн асуудал тодорхойгүй байна. Мөн зайн сургалт зохион байгуулах цахим сургалтын программ шаардлагатай. Онлайн сургалтын давуу тал нь суралцагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран байгаа газраасаа хүссэн цагтаа интернэтэд холбогдон сургалтуудыг авах боломжтой. Мөн сургалтад хамрагдах гэж хөдөө орон нутгаас ирэх тээврийн зардал, байрлах зардал зэрэг суралцагчаас гарах зардлуудыг хэмнэж өгдөг. Одоогийн нөхцөл байдлын хувьд COVID-19 өвчлөлтэй холбоотойгоор 2020 онд багц цагийн сургалт явагдах боломжгүй байгаа энэ үед цахим сургалт гол үүрэг гүйцэтгэнэ. Онлайн сургалтын олон хэлбэрийг бий болгох. Жишээлбэл: Өнөөдрийн байдлаар өрхийн анагаах ухааны хамгийн сүүлийн үеийн мэдээ мэдээллийг эмч, эмнэлгийн мэргэжилтэнд шуурхайн хүргэх явдал туйлын хангалтгүй байна. Бусад улс орнуудад өрхийн анагаах ухаан, анхан шатны тусламж үйлчилгээнд нэн чухал ач холбогдол бүхий шинжлэх ухааны ололт амжилт, онолуудыг эмч, эмнэлгийн мэргэжилтэнд цаг алдалгүй хүргэж байдаг сэтгүүлтэй. Манайд АШУҮИС-ийн Innovation сэтгүүл байдаг. /судлах/

- Хөтөлбөрийн үнэлгээ: Журамд заасан үнэлгээтэй холбоотойтой заалт хэрэгжихгүй байгаагийн шалтгаан бол үнэлгээ хийх ЭМХТ-ийн хүний нөөцийн чадавхи байхгүй байгаатай холбоотой. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн баг ажиллуулах шаардлагатай. Энэ асуудлыг ЭМХТ зохион байгууллах боломжтой.
- Явцын хяналт: Багц цагийн сургалтын хувьд ЭМХТ-д тасралтгүй сургалтын зохицуулалт хариуцсан 1 мэргэжилтэн ажиллах ба улсын хэмжээнд сургалт эрхэлж буй сургалт эрхлэх байгууллагын багц цагийн сургалтын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавж чаддаггүй. Мөн сургалтын цахим систем байхгүйгээс сургалт эрхлэх байгууллагын зохион байгуулж буй сургалт, олгож буй гэрчилгээ, багц цаг болон бүртгэлийн асуудлыг хяналтандаа авч чадахгүй байна.

2.3 Багц цагийн сургалтын хэлбэр ба цахим сургалтын эрх зүйн орчин:

Эрүүл мэндийн сайдын “Мэргэшүүлэх болон тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалт эрхлэх байгууллагыг сонгох, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам” 2017 оны А/337 тоот тушаалд багц цагийн сургалтын онлайн хэлбэр, зайн сургалттай холбоотой хэд хэдэн заалт тусгагдсан байдаг. Үүнд:

2.4-д зааснаар Төгсөлтийн дараахь сургалт нь зайн сургалтын хэлбэрээр явагдаж болно гэж тусгасан байдаг. Эрүүл мэндийн хөгжлийн төвд зайн сургалтын төв ажиллаж байгаа боловч Эмнэлгийн мэргэжилтний багц цагийн богино хугацааны сургалтад ашиглалт хангалтгүй байна.

3.4.17. төгсөлтийн дараахь зайн сургалтын журмыг боловсруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын шийдвэрээр батлуулах, зайн сургалтын төвийн үүрэг гүйцэтгэн, сургалт эрхлэх байгууллагын дэргэдэх зайн сургалтын салбар төвийг байгуулахад дэмжлэг үзүүлж, үйл ажиллагааны уялдааг зохицуулах гэж заасан байдаг. Одоогоор Төгсөлтийн дараахь зайн сургалтын журамгүй. Тус төвийн дэргэд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд зайн сургалт зохион байгуулах тоног төхөөрөмтэй сургалтын танхим бүхий төв нээгдсэн боловч зайн сургалт зохион байгуулагдаж чадахгүй байна.

5.3.3. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэдэх төгсөлтийн дараахь зайн сургалтын төвийн салбар төвийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах гэж заасан. Одоогоор зайн сургалтын төвтэй болсон хэдий ч үйл ажиллагааг нь тогтмолжуулах шаардлагатай.

5.3.4. энэхүү журмын 5.3.3-т заасан төгсөлтийн дараахь зайн сургалтын салбар төв байхгүй тохиолдолд төгсөлтийн дараахь сургалт эрхлэх бусад байгууллагын дэргэдэх салбар төвтэй гэрээ байгуулж, зайн сургалтыг зохион байгуулах. Одоогоор УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, АШУҮИС зэрэг байгууллагууд зайн сургалт зохион байгуулдаг. Эмнэлгүүдийн хувьд зайн сургалтыг ихэвчлэн зөвлөгөө, мэдээллийн журмаар ашигладаг. Багц цагийн богино хугацааны сургалтад зайн сургалтыг идэвхтэй ашиглаж хамтран ажиллаж байгаа байгууллага одоогоор байхгүй байна.

Төгсөлтийн дараахь сургалтын гол журам болох Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалд заасан журмын Ажлын албаны чиг үүргийн 3.4.2-д “Энэхүү журмын хүрээнд төгсөлтийн дараахь сургалтын чиглэлээр шаардлагатай нэмэлт дүрэм, журам, заавар, гарын авлага... боловсруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлаар батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах, тухай бүр шинэчлэх” гэж заасан тул эрх зүйн баримтуудын хэрэгжилтээс харахад багц цагийн богино хугацааны сургалттай холбоотой заалтууд хэрэгжих боломжтой харагдаж байна. А/337 журмын дагалдах дүрэм, журам, зааврыг боловсруулж, мөрдүүлж болох тохиолдолд одоо хэрэгжиж байгаа журмын заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

- 3.1 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь багц цагийн богино хугацааны сургалттай холбоотой эрх зүйн баримтад тусгасан заалтын хэрэгжилтийн байдлыг авч үзэхэд хэрэжиж байгаа- 11, дутуу хэрэжиж байгаа- 5 , хэрэгжихгүй байгаа -8 заалт буюу журмын хэрэгжилт хангалтгүй байна. Багц цагийн сургалтын нэгдсэн бүртгэл, мэдээний сан байхгүй байгаа нь жил бүр зохион байгуулагдаж буй багц цагийн сургалтын хөтөлбөрийн агуулга, өөрчлөлт, шинэчлэлтэд үнэлгээ өгөх, шийдвэр гаргалтад ашиглах боломжгүй байна. Сургалтын чанарт, сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийгдэхгүй байгаа нь нэг талаас хүний нөөцийн дутагдал, нөгөө талаас хүний нөөцийн чадавхи сул байгааг харуулж байна. Мөн тасралтгүй сургалт

эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлийн бүрэлдэхүүн нь олон талыг төлөөлөх төлөөлөл болж чадахгүй байна.

3.2 Одоогийн журамд багц цагийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах талаарх хэд хэдэн заалт дэлгэрэнгүйгээр тусгагдсан боловч хэрэгжилт хангалтгүй байна. А 337-р тушаалын хүрээнд тасралтгүй сургалтыг зайн хэлбэрээр явуулахтай холбогдуулан хэд хэдэн заалт дэлгэрэнгүйгээр тусгагдсан буюу 2.4, 3.4.17, 5.3.3, 5.3.4 зэрэг заалтудад тасралтгүй сургалтыг зайн сургалтын хэлбэрээр явагдаж болох бөгөөд төгсөлтийн дараахь зайн сургалтын журмыг боловсруулж, үйл ажиллагааны уялдааг зохицуулах; зайн сургалтын төвийн салбар төвийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах зэргээр заагдсан боловч энэхүү үйл ажиллагаа нь хэрэгждэггүй.

3.3 Одоогийн журамд багц цагийн сургалтыг зайн хэлбэрээр зохион байгуулах талаарх заалт тусгагдсан хэдий ч цахим сургалт явуулах журам байхгүй, цахим сургалтын программ байхгүй, цахим сургалтын сан байхгүй байна. Иймд зайн сургалтын журмыг нэн тэргүүнд боловсруулан, сургалт эрхлэх байгууллагуудад танилцуулан хамтран ажиллах шаардлагатай.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

4.1 Сургалтын эрх зүйн баримтыг шинэчлэх, сайжруулах талаар:

Төгсөлтийн дараах сургалтын гол журам болох Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/337 дугаар тушаалд заасан журмын Ажлын албаны чиг үүргийн 3.4.2-д “ Энэхүү журмын хүрээнд төгсөлтийн дараах сургалтын чиглэлээр шаардлагатай нэмэлт дүрэм, журам, заавар, гарын авлага... боловсруулж, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлаар батлуулан, хэрэгжилтийг зохион байгуулах, тухай бүр шинэчлэх” гэж заасан тул эрх зүйн баримтуудын хэрэгжилтээс харахад багц цагийн богино хугацааны сургалттай холбоотой заалтууд хэрэгжих боломжтой харагдаж байна.

I. А/337 журмын дагалдах дүрэм, журам, зааврыг боловсруулж, мөрдүүлж болох тохиолдолд одоо хэрэгжиж байгаа журмын заалтуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж байна. Журмын хэрэгжилт дээр анхаарч цаашид:

- Эрүүл мэндийн сайдын А/484 тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах буюу эмнэлгийн мэргэжилтний хүний нөөцийн мэдээний сантай болох.
- Эрүүл мэндийн сайдын А 337 журмын хүрээнд зайн сургалттай холбоотой заалтууд дээр дурдсанчлан хэрэгжихгүй байгаа тул 2.4, 3.4.17, 5.3.3, 5.3.4 заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллах. Зайн сургалтын журмыг шинээр боловсруулан гаргаж ЭМХТ-ийн захирлаар батлуулах. Онлайн сургалтын давуу тал нь суралцагч орон зай, цаг хугацаанаас үл хамааран байгаа газраасаа хүссэн цагтаа интернэтэд холбогдон сургалтуудыг авах боломжтой. Мөн сургалтад хамрагдах гэж хөдөө орон нутгаас ирэх тээврийн зардал, байрлах зардал зэрэг суралцагчаас гарах зардлуудыг хэмнэж өгдөг. Одоогийн нөхцөл байдлын хувьд COVID-19 өвчлөлтэй

холбоотойгоор 2020 онд багц цагийн сургалт явагдах боломжгүй байгаа энэ үед цахим сургалт гол үүрэг гүйцэтгэнэ.

- Сургалтын явцын хяналтыг сайжруулах буюу жил бүрийн сургалтын агуулга хир шинэчлэгдэж байгаа, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх түвшин байгаа эсэхийг өмнөх оны сургалтын хөтөлбөртэй харьцуулан үнэлэх зэргээр зохион байгуулах.
- Журмын 3.4.28 заалтын хүрээнд ХНБЗА-нд ажиллах хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах буюу мэргэжилтний тогтворгүй байдлаас 2018, 2019 онд элсэгч суралцагч, төгсөгчтэй холбоотой цахим мэдээний санг тогтмол ажиллуулах, боловсронгуй болгох, хяналт тавих үйл ажиллагаа хийгдээгүй байна.

II. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Ерөнхий захирлын “Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай” 2018 он А/29, 2019 он А/165 журам:

- Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэх /А165/, ажиллах журмыг шинэчлэн боловсруулах /А29/. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэдэх Тасралтгүй сургалт эрхлэх зөвшөөрөл олгох зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, эрх үүргийг тодорхой болгох шаардлагатай. Мөн энэ зөвлөлийн чадавхийн асуудал чухал үүрэгтэй. Одоо ажиллаж байгаа зөвлөлийн бүрэлдэхүүн нь олон талыг төлөөлөх төлөөлөл болж чадахгүй байна.

4.2 Сургалт зохион байгуулах байгууллагын түвшинд:

- Зайн сургалтын төв бүхий сургалт эрхлэх байгууллагуудтай хамтран ажиллах /УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, АШУҮИС/
- Сургалт эрхлэх байгууллагуудаас тасралтгүй сургалтын чанарыг сайжруулах талаар санал авах
- Хөтөлбөрийн агуулга болон үнэлгээний асуудлаар мэргэжлийн багийг гэрээгээр ажиллуулах. Жишээлбэл: Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн асуудлаар ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороотой хамтран ажиллах.
- Мөн тасралтгүй сургалтыг арилжааны ашиг сонирхлоос ангид байх тал дээр анхааран, дүрэм журмандаа тусгах. АНУ-ын Тасралтгүй сургалтын Магадлан итгэмжлэх комиссоос тасралтгүй сургалтын арилжааны ашиг сонирголоос гадуур байх шаардлагуудыг тавьж, дүрэм журмандаа тусгасан байдаг. Цаашдаа бид эмийн компани болон бусад компаний санхүүжилтээр богино хугацааны багц цаг бүрдүүлэлтийн сургалтууд явагддаг тоо статистикийг гаргах. Бүр мөсөн хориглохгүй ч гэсэн тодорхой хязгаарлалтуудыг тавих, түүнийг журамд тусгах тал дээр анхаарах шаардлагатай.

Багц цагийн богино хугацааны сургалтын эрх зүйн баримт, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх үр дүн

- Ажлын албаны хүний нөөцийн чадавхийг сайжруулах, үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай.

4.3 Сургалт эрхлэх байгууллагын түвшинд:

- СЭБ-үүд, мэргэжлийн холбоод өөрсдөө тухайн чиглэлийн эмч, мэргэжилтнүүдийн цахим мэдээллийн санг үүсгэж түүндээ суурилж сургалтын хэрэгцээ, чиглэлээ тодорхойлон гаргаж, агуулгаа шинэчлэн өөрчилж, сургалтын хэлбэрээ аль болох олон янзаар явуулж, тухайн чиглэлийн сургалтаа эрхлэх.
- Онлайн сургалтын олон хэлбэрийг бий болгох шаардлага тавих. Жишээлбэл: Өнөөдрийн байдлаар өрхийн анагаах ухааны хамгийн сүүлийн үеийн мэдээ мэдээллийг эмч, эмнэлгийн мэргэжилтэнд шуурхайн хүргэх явдал туйлын хангалтгүй байна. Бусад улс орнуудад өрхийн анагаах ухаан, анхан шатны тусламж үйлчилгээнд нэн чухал ач холбогдол бүхий шинжлэх ухааны ололт амжилт, онолуудыг эмч, эмнэлгийн мэргэжилтэнд цаг алдалгүй хүргэж байдаг туршлагыг судлан нэвтрүүлж мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх хэрэгтэй гэж үзлээ.